


БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН  
/Эхний хагас жил/

2024 он

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 06 дугаар сарын 14

Тус газар нь нийгмийн даатгалын сангуйдын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь тавьж олгох, ажил олгогч, даатгуулагч иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, мэдээллийн систем хөгжүүлэх төслийн хүрээнд ажилтан, албан хаачдыг сургах, мэдлэг үр чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах зэрэг ажлыг хэрэгжүүлж, Нийгмийн даатгалын төв, орон нутгийн хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”, дүүргээс “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж байна.

**Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт,  
зарцуулалтын талаар**

2024 оны 6 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн 1.5 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгөөс 1.3 тэрбум төгрөгийг санд хурилтуулж, 96.6 хувиар, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчдын шимтгэл 70.4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 36.4 төгрөгийг хурилтуулж 51.7 хувиар тус тус биелэгдсэн.

Тайлант хугацаанд нийт 745 тэтгэвэр авагчдад нийт 2 тэрбум 999.7 сая төгрөгийг зарцуулсан. Зарцуулалтыг тэтгэврийн төрлөөр харуулбал:

- Өндөр нас-1.9 тэрбум төгрөг,
- Хөдөлмөрийн чадвар алдсаны -227.1 сая төгрөг,
- Тэжээгчээ алдсаны-370.6 сая төгрөг,
- Цэргийн тэтгэвэр- 411.1 сая төгрөг,
- ҮОМШӨ-ний- 36.4 сая төгрөгийг,

Нийгмийн даатгалын тэтгэмжийн даатгалын сангаас 108 даатгуулагчид 140.8 сая төгрөгийг зарцуулсан. Төрөлжүүлбэл:

- Жирэмсэн амаржсаны-99.8 сая төгрөг,
- ХЧТА-ын -8.3 сая төгрөг,
- Ажилгүйдлийн тэтгэмж- 68.2 сая төгрөг,
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж-12.0 сая төгрөгийг тус тус иргэд, даатгуулагчдад олгож зарцуулсан байна.

**Сангийн төвлөрүүлэлт, хуваарилалтын талаар:**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/170 тоот тушаалаар НДС-ийн мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах арга хэмжээний дагуу ниймийн даатгалын шимтгэлийн орлогыг өдөр бүр дээд шатны байгууллагад нийт 1 575.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн.

Тодруулбал:

- Тэтгэврийн даатгалын сан 1 529.0 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын сан 20.0 сая төгрөг
- ҮОМШӨ даатгалын сан 10.0 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сан 16.0 сая төгрөгийг тус төвлөрүүлжээ.

Нийт 871.5 сая төгрөгийг сан хооронд хуваарилж, холбогдох сангудаас гарах зардлыг иргэд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгож үйлчилгээ үзүүлсэн.

- Тэтгэврийн даатгалын сан 862.2 сая төгрөг
- Тэтгэмжийн даатгалын сан 3.0 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сан 6.0 сая төгрөгийг хуваарилалт хийн ажилласан байна.

Нийгмийн даатгалын сангаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж бусад зардлыг сан тус бүрээр, аж ахуйн нэгж байгууллагуудад үйл ажиллагааны зардлыг шилжүүлэхийн өмнө батлагдсан төсөв хүрэлцээтэй эсэхийг хянан баталгаажуулж зарлагын гүйлгээ хийдэг.

### Нийгмийн даатгалын хамралт, өр авлага барагдуулалтын талаар

Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Няглан бodoх бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тушаал шийдвэр, Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэн сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 62 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авсан бөгөөд 30 ажил олгогчийн 252.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг үлдэгдлийн баталгаагаар тооцоо нийлэн ажилласан.

Тайлант хугацаанд:

- Ажил олгогч-62
- Нийгмийн даатгалын албан журмын даатгуулагч-1092,
- Сайн дурын даатгуулагч-95 тус тус хамрууллаа.

2024 оны эхний 140.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 25.8 сая төгрөгийг буюу 18.4 хувиар бууруулсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулахаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/199 дүгээр тушаалаар баталсан журманд зааснаар насжилтыг ангилж шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж, өмнөх онд 2 ажил олгогчийн 4 гүйцэтгэх хуудас бүхий 57.8 сая төгрөгийн авлагыг албадан гүйцэтгүүлэхээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлснээс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна. 2 ажил олгогчийн 14.1 сая төгрөгийн авлагыг шүүхээр хялбаршуулсан журмаар шийдвэрлэж гэрээ байгуулсан.

Өртэй 6 төсвийн байгууллагын 78.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, албан шаардлага хүргүүлсэн мөн дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичиг хүргүүлсэн. 30.1 сая төгрөгийн урсгал авлага үүссэн байна.

### Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллогын талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Маягт батлах тухай” 323 дугаар тогтоолоор баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг захиргааны статистикийн маягтын дагуу эд хөрөнгийн бүртгэл, тайланг цахим системд 2024 оны 03 дугаар сард бүртгэсэн.

Байгууллагын хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх тухай газрын даргын 2024.06.05-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар 2023.06.05-наас 2023.06.07-ны хооронд тооллогыг зохион байгуулж, тооллогоор 28.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 21.0 сая төгрөгийн тавилга эд хогшил, 8.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 43.0 сая төгрөгийн конторын байр нийт 101 203 829.01 мөнгөний хөрөнгө тоологдсон.

### Дотоодын болон бусад хяналт шалгалтын талаар

Дотоод хяналт шалгалт хийх тухай журмын дагуу тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтод хяналт шалгалтыг эхний хагас жилд хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар 7 жилийг 5 жилийн цалингаар өөрчлөн тогтооходоо буруу жилийг тооцож 2 тэтгэвэр авагчид 918.0 мянган төгрөг, 1 тэтгэвэр авагчид 550.0 мянган төгрөгийг давхардуулан, өмнөх онд 2 тэтгэвэр авагчид хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бүрэн эрх үүсгэн 2.0 сая төгрөг, 1 даатгуулагчид жирэмсэн амаржсаны тэтгэмжийг давхардуулан 920.0 мянган төгрөгийг тус тус илүү олгосон зөрчил илэрсэн. Нийт зөрчлийн 4.4 сая төгрөгөөс 2.9 сая төгрөгийг барагдуулж, үлдэгдэл 1.5 сая төгрөгийг шуурхай барагдуулахаар ажиллаж байна.

Өмнөх оны Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийн 6.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 0.9 сая төгрөгийг барагдуулж, 5.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийслэлийн аудитын газар, “Өлзийт экаунт” ХХК аудитын байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж 2023 оны ажлаа шалгуулж, 2 зөвлөмж, 3 албан шаардлагатай, зөрчилгүй дүгнэгдсэн. Албан шаардлага, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, биелэлтийг 2024.06.30-нд өгөхөөр хугацаатай байх бөгөөд НДЕГ-ын Хяналт шалгалтын газар 2021-2023 оны ҮОМШӨ-ний даатгалын санд хяналт шалгалтыг 4 дүгээр сард хийсэн бөгөөд шалгалтын дүгнэлт ирээгүй байна

Мэдээллийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд:

Сангийн мэдээ-59,

Санхүүгийн мэдээ-53,

Хүний нөөцтэй холбоотой-25 мэдээллийг бүрэн шивж оруулсан байна.

Иргэдэд мэдээллийг нээлттэй, ил тод хүргэхэд шилэн дансны тухай хуулинд заасан мэдээ, мэдээллүүдийг шилэн дансны цахим системд, мэдээллийн самбарт, байгууллагын фэйсбүүк хуудсанд нээлттэй байршуулж, мөн ажлын байрны сул орон тооны зарыг дүүргийн ХХҮХ, ЗДТГ-ын хэвлэл, мэдээллээр дамжуулан нээлттэйгээр хүргүүлэн ажилласан.

Ажил олгогч, даатгуулагчийн мэдээлэл нийгмийн даатгалын цахим системд үнэн зөв бүртгэгдсэн эсэхэд хянаж үзэхэд:

## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Ажил олгогч-62

АЖДаатгуулагч-1092

СДД-95 бүртгэгдсэн байна. 1 ажил олгогчийн РД буруу бүртгэгдсэнийг засуулахаар МТТөвд албан бичгээр хандсан, 1 ажил олгогчийн нэр өөрчлөгдсөнийг хүсэлтийг үндэслэн өөрчлөн бүртгэсэн. Бусад ажил олгогч, даатгуулагчийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдээгүй байна.

### Архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны талаар

Албан хэрэг хөтлөлтийн өрг цахим системээр 123, able програмаар 113 албан бичиг ирснийг хүлээн авч бүртгэл хөтлөн хэлтсийн даргад танилцуулан хариутай 79 албан бичгийг холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлсэн ба бусад байгууллагуудад 40 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан явуулж ажилласан.

Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлсэн иргэдэд нийгмийн даатгалын лавлагаа цахим мэдээллийн сангаас:

- QR кодтой-45,
- архивын цаасан баримтаас шүүж-13,
- Харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хүсэлтийн дагуу-11 лавлагааг гарган өгсөн.

Мөн иргэд, даатгуулагчдын хүсэлтээр тэдэнд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор харьяа бусад хэлтсүүд рүү 6 хүсэлтийг дотоод сүлжээгээр дамжуулан авч даатгуулагчдын тэтгэврийг хугацаа алдалгүй тогтоож ажилласан.

2024 оны 6 сарын байдлаар дээд газрын 40 тогтоол, шийдвэр ирснийг албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.

Тогтоол шийдвэрийг төрөлжүүлбэл:

- Засгийн газрын тогтоол-1
- Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал - 7
- Монгол Улсын сангийн сайдын тушаал-1
- Улсын ерөнхий прокурор хууль зүй,Дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал1
- НЗД-ын захирамж-4
- БХДЗД-ын захирамж-10
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол-1
- НДЕГ-ын даргын тушаал-12
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал-1
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын тушаал-1
- Багахангай дүүргийн онцгой комиссын даргын тушаал-1

зэрэг 40 тогтоол шийдвэр ирсэн бөгөөд 11 тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг ханган, бусад шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Албан хаагчид нөөц бололцоогоо ашиглан архивын өрөөний тавиурыг өөрсдөө хийж тохижуулан, архивын нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хэсгийг томилон ажиллуулж байна.

2024 оны архивын хөтлөх хэргийн жагсаалтын дагуу 80 хадгаламжийн нэгжийг албан хаагчдаас хуваарийн дагуу хүлээн авсан ба албан хаагчдад 41 баримтыг бүртгэл хөтлөн ашиглуулант ажилласан бөгөөд байгууллагын архивт:

## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

- Байнга хадгалах-223
- 70 жил хадгалах- 357
- Түр хадгалах- 339 нийт 919 баримт хадгалалтын горимын дагуу хадгалагдаж байна.

Байгууллагын баримт няглан шалгах комисс хуралдаж 2024 оны архивын хөтлөх нэрийн жагсаалтыг шинэчлэн үлгэрчилсэн жагсаалт-89 салбарын жагсаалт-23 баримтын жагсаалтыг газрын даргын тушаалаар батлав.

Салбарын хэмжээнд мэдээллийн систем хөгжүүлэх төслийн хүрээнд ажил олгогчийн болон сайн дурын даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого таниулах, банкны орлого зарлагын хуулга оруулах, эд хөрөнгийн бүртгэл болон орлого зарлага шивэх ажлууд бүрэн, тэтгэвэр, тэтгэмжийн өглөг хаалт 90 хувьтай, 61 тэтгэвэр, 108 тэтгэмжийн тогтоолт, олголт хийгдсэн. Шинэ системээр цэргийн тэтгэвэр авагчийн ажилласан жилийн нэмэгдэл хийгдээгүй 4 тэтгэвэр хүлээгдэж байна.

Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхээр ХХҮХ-ээс хэрэгжүүлж байгаа төсөлд хамрагдсан иргэдийг, мөн дүүргийн ХАА-н тасаг, ХХҮХ-тэй хамтран шинэ хоршоо хөдөлгөөнд нэгдэж байгаа малчдыг сайн дурын нийгмийн даатгалд хамруулахаар хамтран ажиллаж байна.

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-өөр дүүргийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Орос улсын түүх, соёл, өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчилж, мөн дүүргийн эмэгтэй өрх толгойлсон 4 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлэв.

### Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын талаар:

Газрын хэмжээнд тайлант хугацаанд 7 иргэнээс өргөдөл гаргасан ба холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэж, гомдлын шинжтэй 2 өргөдлийн хариуг албан бичгээр шуудангаар, бусад өргөдлийн хариуг утсаар болон иргэнтэй уулзаж амаар өгсөн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна. Шийдвэрлээгүй буюу хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл байхгүй. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг мэдээллийн самбарт нээлттэй байршуулдаг.


Газрын даргын боловсон хүчиний 16, үйл ажиллагаатай 9 захирмжлалын захирамжлалын баримт бичгийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулан гаргасан.

### Сургалт сурталчилгааны талаар:

Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч орд ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Төмөр замын БЗАҮАнги, 12-р хэсэг, 44-р цэцэрлэг зэрэг 6 ажил олгогч байгууллагын 163 даатгуулагчдад шинэчилсэн хуулийн сургалтыг, Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс албадын мэргэжилтнүүдийн хамт дүүргийн шугам замын өртөө болон малчин өрхөд явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 2 удаа 18 өрхийн 63 иргэнд нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэн хууль сурталчлан ажилласан.


ЕБС-ийн төгсөх ангийн 2 бүлгийн 71 сурагчдад сайн дурын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хамрагдахын ач холбогдлыг танилцуулах сургалтыг 1 удаа зохион байгуулав.

## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР



Нийгмийн даатгалын хуулийг сурталчилсан шторкийг дүүргийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллээр дамжуулан дүүргийн иргэдэд, Нийгмийн даатгалын ерөнхий газраас цахим хуудсаараа дамжуулан хүргэж байгаа нийгмийн даатгалын хууль болон үйлчилгээтэй холбоотой 33 удаагийн видео бичлэгийг “Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар” пэйж хуудсаар, мөн албан хаагчид өөрсдийн фэйсбүүк хуудсаар шейрлэж нийгмийн даатгалын хуулийг сурталчилж байна.

Байгууллага дотооддоо 4 ажилтан, албан хаагчдад нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн сургалтыг 2 удаа, байгууллагын ЭБАТ авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулсан. Шинээр томилогдсон 1 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг танилцуулж, нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн мэдээлэл өгч, уншиж судлах ном, гарын авлагаар хангаж ажиллав.



## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

### Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон нэмэлт ажлын талаар:

Хэлтсийн даргын 2023.05.17-ны өдөр “Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг А/17 дугаар тушаалаар 2 жилийн хугацаатай баталсан. Хөтөлбөрт тусгаснаар газрын гадна болон дотоод засварын ажлыг хийж албан хаагчдын ажиллах ая тухтай орчин бурдүүлсэн. Мөн 3 ахмад настанг “Сар шинийн баяр”-аар хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Мөн МУ-ын ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа гурван тулгуурт хөдөлгөөний нэг “Эрүүл монгол хүн- эко аялалын өдөрлөг”-ийг Багануур, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулж, албан хаагчдын хамт оролцов.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Тэтгэвэр нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор нийт 744 тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100000 төгрөгөөр нэмэгдүүлэх ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

Өндөр насны-614

Хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр – 93

Тэжээгчээ алдсаны-37 нийт 744 тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлж, 74.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

ХЯНАСАН:

ДАРГА



А.МӨНХЦЭЦЭГ

Б.БАЯРТУЯА